



ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ



“Инновац, сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үр ашгийн олон улсын үзэсгэлэн, конференц”-д зориулав.

Улаанбаатар хот
2024



АГУУЛГА



01

ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН



02

ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ




03

**ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ӨӨРЧЛӨХ
ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА**



04

**ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН
ТАЛААР**





01 ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН





ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Төрийн байгууллага

Албадлага Урамшуулал

- Төрийн бодлого, хууль
- Дүрэм, журам
- Норм, стандарт



Хэрэглэгч

Зорилтот бүлэг


- Үүрэг хүлээсэн хэрэглэгч
 - Эрчим хүчний салбар
 - Аж үйлдвэрийн салбар
 - Барилгын салбар
- Бусад хэрэглэгч



ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх

Алсын хараа 2050



3 жилд

2016
2019
2023

- Эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих;
- Эрчим хүчний хэмнэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг урамшуулах.

- Үүрэг хүлээсэн хэрэглэгчтэй холбоотой;
- Эрчим хүчний Аудит хийхтэй холбоотой;
- Аудитор, менежер бэлтгэх, мэргэшүүлэх сургалт, гэрчилгээ олгохтой холбоотой;
- Аудитын байгууллага, Мэргэжлийн байгууллагыг магадлан итгэмжлэхтэй холбоотой;



ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

Эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийг **хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах;**

- эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай зарцуулах чиглэлээр **бараа бүтээгдэхүүн, материал, эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх болон эрчим хүч хэрэглэх машин, тоног төхөөрөмж, барилга** байгууламж, ажил, үйлчилгээнд мөрдөх норм батлах, стандарт батлуулах;

- эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлогыг **хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийг** Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хүргүүлэх;



ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Олон улсад

- Эрчим хүчний хэмнэлтийн хуультай **62 улс**
- Хэмнэлтийн бодлого, хөтөлбөртэй **51 улс**
- Эрчим хүчний хэмнэлтийн байгууллага **56 улс**
- Яам болон бусад байгууллагатай хамтарсан **75 улс**

1. Эрчим хүч хэмнэлтийн талаарх **төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах**, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах
2. Үүрэг хүлээсэн хэрэглэгчдийг **тодорхойлж бүртгэх**, мэдээ тайлан авч, эрчим хүчийг хэмнэхэд чиглэсэн ажил, арга хэмжээг мэргэжлийн арга зүйгээр хангах




3. Эрчим хүчний аудитор, Эрчим хүч **хэмнэлтийн менежерийг бэлтгэх, мэргэшүүлэх**, эрчим хүч хэмнэлтийн мэргэжлийн байгууллагуудад **магадлан итгэмжлэл олгох**
4. Эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай хэрэглээний мэдээллийн систем хөгжүүлэх, **нийтэд сурталчлах, танин мэдүүлэх** ажлыг зохион байгуулах;



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРОО


Тайлагнал



Хэмнэлтийн менежер



Үйл ажиллагаа



Гэрчилгээ

Эрчим хүчний аудит

Үйлчилгээ

Хэмнэлт
Үр ашиг

Импорт буурах
Чадлын дутагдал
буурах

Бүтээмж
Технологийн
дэвшил

Хүлэмжийн
ялгаралын
бууралт

Зардлын
бууралт



02 ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ





ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ



2017 ОНООС ХОЙШ



ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

ҮХХ-ИЙН ЖИЛИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭНИЙ БОСГО ХЭМЖЭЭ

ЗАСГИЙН ГАЗРЫН 2019 ОНЫ 182 ДУГААР ТОГТООЛ

А. Барилга байгууламж өмчлөгч, эзэмшигч иргэн, аж ахуйг нэгж байгууллага:

1. 3000 м² ба түүнээс дээш талбай бүхий төрийн болон орон нутгийн төсөвт байгууллага:

300 кВт.ц/ м² жил болон түүнээс дээш

2. 5000 м² ба түүнээс дээш талбай бүхий бусад аж ахуйн нэгж, байгууллага:

300 кВт.ц/м² жил болон түүнээс дээш

Б. Эрчим хүч хэрэглэгч: (Цахилгаан болон дулааны эрчим хүчний нийт хэрэглээгээр тооцно.)

1. Уул уурхай (олборлох, боловсруулах үйлдвэр):

5,000 МВт.ц/жил болон түүнээс дээш

2. Бусад үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага:

4,000 МВт.ц/жил болон түүнээс дээш

В. Эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага:

1. Эрчим хүч үйлдвэрлэгч (дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүч):

10 хувь/жил болон түүнээс дээш

2. Эрчим хүч дамжуулагч (цахилгаан эрчим хүчний алдагдал):

2 хувь/жил болон түүнээс дээш

3. Эрчим хүч түгээгч:

ЦЭХ-ний алдагдал:

9 хувь/жил болон түүнээс дээш *

ДЭХ-ний алдагдал:

7 хувь/жил болон түүнээс дээш

* Цахилгаан түгээх сүлжээний алдагдалд шууд хэрэглэгчийн борлуулалтын утгыг тооцохгүй.

ЗАСГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ 67 ДУГААР ТОГТООЛ

А. Барилга байгууламж өмчлөгч, эзэмшигч иргэн хуулийн этгээд:

1. Төрийн болон орон нутгийн төсөвт байгууллага, хуулийн этгээд (15,000 м³ дээш эзлэхүүн бүхий)*:

80 кВт.ц/ м³ жил

2. Бусад иргэн, хуулийн этгээд

2.1. Худалдаа, оффис (30,000 м³ дээш эзлэхүүн бүхий):

80 кВт.ц/м³ жил

эсхүл 3,000 МВт.ц/жил

2.2. Үйлчилгээ (20,000 м³ дээш эзлэхүүн бүхий):

80 кВт.ц/м³ жил

Б. Эрчим хүч хэрэглэгч иргэн, хуулийн этгээд: (Эрчим хүчний жилийн хэрэглээг хэрэглэгчийн цахилгаан, уур, дулааны нийлбэр хэмжээгээр тооцно.)

3. Уул уурхай (олборлолт, боловсруулалт): 4,000 МВт.ц/жил

4. Боловсруулах бусад үйлдвэр

4.1. Хүнд үйлдвэр:

3,000 МВт.ц/жил

4.2. Дунд/ хүнсний үйлдвэр:

2,000 МВт.ц/жил

4.3. Хөнгөн үйлдвэр:

2,000 МВт.ц/жил

5. Мэдээлэл, холбоо:

3,000 МВт.ц/жил

6. Бусад:

2,000 МВт.ц/жил

В. Эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд:

7. Эрчим хүч үйлдвэрлэгч (дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүч):

10 хувь/жил,

эсхүл 2,000 МВт.ц/жил

8. Эрчим хүч дамжуулагч (дамжуулах сүлжээний алдагдал):

2 хувь/жил

9. Эрчим хүч түгээгч, хангагч:

ЦТС-ний алдагдал:

9 хувь/жил

ДТС-ний алдагдал:


7 хувь/жил

* Төрийн нууцын тухай хуульд заасан байгууллага, байршил, мэдээлэл бүхий хуулийн этгээд, Барилгын тухай хуулийн 14.6-д заасан хугацаанд ашиглаж буй барилга байгууламж болон төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, орон сууцны хэрэглэгчийг үүрэг хүлээсэн хэрэглэгчээр бүртгэхгүй.




ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн тоо



- Барилга байгууламж - 25
- Уул уурхай (олборлох, борлуулах үйлдвэр) - 41
- Хүнд үйлдвэр - 20
- Хөнгөн, хүнсний үйлдвэр - 80
- Бусад - 34
- Эрчим хүчний салбар - 26



- ЦЭХ-ний нийт хэрэглээ
- 2018 оны хэмнэлт
- 2019 оны хэмнэлт
- 2020 оны хэмнэлт
- 2021 оны хэмнэлт
- 2022 оны хэмнэлт
- 2023 оны хэмнэлт

2018 он: 51.7 сая кВт.ц буюу 8.5 тэрбум төгрөг

2019 он: 68.5 сая кВт.ц буюу 11.3 тэрбум төгрөг


2020 он: 69.5 сая кВт.ц буюу 8.2 тэрбум төгрөг

2021 он: 38.4 сая кВт.ц буюу 6.7 тэрбум төгрөг

2022 он: 18.7 сая кВт.ц буюу 6.8 тэрбум төгрөг



2023 он: 16.9 сая кВт.ц буюу 6.2 тэрбум төгрөг

Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн ЦЭХ сая кВт.ц/жил




- Барилга байгууламж - 121.47
- Уул уурхай - 3,089.47
- Хүнд үйлдвэр - 374.35
- Хөнгөн, Хүнсний үйлдвэр - 197.14
- Бусад - 196.84
- Эрчим хүчний салбар - 2,042.87

ДНБ, үйлдвэрлэлийн аргаар ноогдох ЦЭХ





Хэрэглэгчдийн цахилгааны нийт хэрэглээ 7,347.2 сая кВт.ц (Оюутолгой ороогүй дүнгээр)





ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, АУДИТ ХИЙСЭН БАЙДАЛ

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж эхэлснээс хойш буюу 2016 оноос өнөөг хүртэл **226** үүрэг хүлээсэн хэрэглэгчээс **150** байгууллага давхардсан тоогоор **212** аудит хийлгэсэн байна.

	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Хийлгэсэн аудитын тоо	20	37	21	42	29	38	25

Аудитын зөвлөмжийн хэрэгжилт

Үүрэг хүлээсэн хэрэглэгч	Гүйцэтгэсэн аудитын тоо	Зөвлөмжилсөн арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хэмнэсэн эрчим хүч мян.кВт.ц	Бууруулсан зардал сая.төг	Зарцуулсан ХО сая.төг
Барилга байгууламж	9	104	20	5957.8	109.0	1281.3
Эрчим хүч хэрэглэгч	11	267	61	6422.6	2198.9	1294.7
Эрчим хүчний салбар	23	333	265	79651.1	8882.5	24291.7
Нийт	43	704	346	92,031.5	11,190.4	26,867.7

Аудитын бүртгэл

Аудит	он								
	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	Нийт
Эхний аудит	20	37	21	36	20	19	11	1	165
Хоёр дахь аудит				6	9	19	11	1	46
Гурав дахь аудит							3		3
Нийт хийгдсэн аудит	20	37	21	42	29	38	25	2	214
2 дахь аудит хийлгэх хугацаа болсон				9	7	15	9	13	53
3 дахь аудит хийлгэх хугацаа болсон							9	7	16
Аудит хийгдээгүй		15	1	11					27
Шинэ ҮХХ-ийн эхний аудит							2	12	12
Нийт 2024 онд аудит хийлгэх									108



ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Олон улсын хамтын
ажиллагааны
байгууллагууд



**GGGI - Даян
дэлхийн ногоон
хөгжлийн
институт**



**GIZ-
ГОУХАН**



**JCM -
Хамтарсан
кредит олгох
механизм**



**USAID -
АНУ-ын
ОУХА**



**KEA, KOICA
- БНСУ-ын олон
улсын хамтын
ажиллагааны
байгууллага**



**Хятадын Эрчим
хүчний
хэмнэлтийн төв**



**Хятадын
Стандартын
үндэсний
хүрээлэн**



ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Олон улсын байгууллагатай хамтран ажиллаж буй чиглэл

№	Байгууллага	Хамтын ажиллагааны чиглэл	Тайлбар
БОДЛОГО, ЭРХЗҮЙ, СУДАЛГАА			
1	Хятадын Эрчим хүчний хэмнэлтийн төв	Эрчим хүчний хэмнэлт болон үр ашгийг нэмэгдүүлэх тал дээр бодит хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх	Байнгын хамтын ажиллагааг идвэхжүүлэх
2	Хятадын Стандартын үндэсний хүрээлэн	Эрчим хүчний хэмнэлт болон үр ашгийн стандарт, норм сайжруулах, шинэчлэх хүрээнд туршлага солилцох, мэдээлэл хуваалцах, дэмжлэг үзүүлэх	
3	GIZ - ГОУХАН	Эрчим хүчний хэмнэлт болон үр ашгийг нэмэгдүүлэх хүрээнд хууль эрхзүйн орчныг сайжруулах, шинэчлэх, механизм бүрдүүлэх	Бага хөрөнгө оруулалт бүхий богино хугацаанд үр дүн өгөх төсөл, судалгааг хийх
4	GGGI - Даян дэлхийн ногоон хөгжлийн институт	Эрчим хүчний хэмнэлт болон үр ашгийг нэмэгдүүлэх хүрээнд хууль эрхзүйн орчныг сайжруулах, шинэчлэх	
5	JCM –Хамтарсан кридет олгох механизм	Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр судалгаа хийх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд харилцан туршлага солилцох, мэдээлэл хуваалцах, дэмжлэг үзүүлэх	Мэдээлэл солилцох, хэмнэлт, СЭХ-ний төсөл хэрэгжүүлэх, CO2 –ыг MRV хийх
6	UN- Нэгдсэн үндэсний байгууллага, түүний төрөлжсөн болон олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газрууд	НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ийн Аж үйлдвэрийн байгууллага, United for Efficiency (U4E) гэх мэт байгууллагуудтай Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан бараа, тоног төхөөрөмж болон эрчим хүчний шошго түүнийг нэвтрүүлэх хүрээнд туршлага солилцох, мэдээлэл хуваалцах, дэмжлэг үзүүлэх 27- Нэгдсэн үндэсний байгууллага, түүний төрөлжсөн болон олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газрууд	Мэдээлэл нээлттэй байх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлийг эрэлхийлэх
7	РТВ - ХБНГУ-ын Физик, техникийн хүрээлэн	Эрчим хүчний салбарт чанарын дэд бүтцийг сайжруулах тал дээр бодит хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх	Төсөлд бодлогын дэмжлэг үзүүлэх
ТӨСӨЛ ХӨГЖҮҮЛЭЛТ, САНХҮҮЖИЛТ			
8	WB - Дэлхийн банк	Ухаалаг тоолуур, ЭСКО төсөл хөгжүүлэлт, Барилгын ногоон гэрчилгээ	Тодорхой зорилтод чиглэсэн санал
9	USAID - АНУ-ын ОУХА	Эрчим хүчний хэмнэлт болон үр ашгийг нэмэгдүүлэх тал дээр бодит хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх	МЭХЗ хөтөлбөр
10	ADB - Азийн хөгжлийн банк	Эрчим хүчний хэмнэлт болон үр ашгийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилт дээр бодит хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх	Бага хөрөнгө оруулалт бүхий богино хугацаанд үр дүн өгөх төсөл, судалгаа ТА - 250,000 USD
11	SDC - Швейцарын хөгжлийн агентлаг	Байгаль орчин, олон нийтийн салбарыг дэмжих жижиг хэмжээний төслийг санхүүжүүлэх хөтөлбөр	Бага хөрөнгө оруулалт бүхий богино хугацаанд үр дүн өгөх төсөл, судалгаа
12	JICA - Япон улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага	Эрчим хүчний хэмнэлт болон үр ашгийг нэмэгдүүлэх тал дээр бодит хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх	ЖДҮ-г дэмжих зээлд орсон, цаашид хэрхэн ҮХХ –д ашиглах боломжийг нээх
13	KEA, KOICA - БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны байгууллага	-	2017 онд Санамж бичиг байгуулж хамтран ажиллах алхмууд тодорхойлогдож, байсан боловч КОВИД19-тэй холбоотойгоор ажлууд удааширсан.
14	Монгол Улсад байнга суугаа гадаад улсын дипломат болон консулын төлөөлөгчийн газрууд	Эрчим хүчний хэмнэлт болон үр ашгийг нэмэгдүүлэх тал дээр бодит хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, нээлттэй мэдээллээр хангах, хамтарсан зөвлөгөөн хийх. 25 улсын Элчин сайдын яам,	-



ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2019-2020 онуудад үндэсний болгон **17 СТАНДАРТ** батлуулсан

стандартууд Байгууллага	Зориулалт	Стандартууд
1 <i>Олон улсын стандартын байгууллага /ISO/</i>	Эрчим хүчний менежментийн тогтолцооны бүлэг стандарт	<ol style="list-style-type: none"> 1. MNS ISO 50001:2019 Эрчим хүчний менежментийн тогтолцоо - шаардлага, хэрэглэх арга зүйн заавар 2. MNS ISO 50002:2019 Эрчим хүчний аудит – шаардлага, хэрэглэх арга зүйн заавар 3. ISO 50003:2019, Эрчим хүчний менежментийн тогтолцоо – эрчим хүчний менежментийн тогтолцооны аудит болон баталгаажуулалт гүйцэтгэх байгууллагад тавих шаардлага 4. MNS ISO 50004 : 2019 Эрчим хүчний менежментийн тогтолцоо – эрчим хүчний менежментийн тогтолцооны хэрэгжүүлэлт, хадгалалт, сайжруулалтын арга зүйн заавар 5. MNS ISO 50006 : 2019 Эрчим хүчний менежментийн тогтолцоо — эрчим хүчний суурь түвшин (эхст) болон эрчим хүчний гүйцэтгэлийн үзүүлэлт (эхгү)-ийг ашиглан эрчим хүчний гүйцэтгэлийг хэмжих нь – зарчим арга зүйн заавар 6. MNS ISO 50007 : 2019 Эрчим хүчний үйлчилгээ — Эрчим хүчний хэрэглэгчийн үйлчилгээг үнэлэх ба сайжруулах арга зүйн заавар
2 <i>Олон улсын цахилгаан техникийн хороо /IEC/</i>	Цахилгаан тоног төхөөрөмжтэй холбоотой стандарт /Шошгожуулалтын журам /	<ol style="list-style-type: none"> 1. MNS IEC 60034-2-1:2019 Эргэлдэгч цахилгаан машин 2-1-р хэсэг: Туршилтаас алдагдал болон А.Ү.К-ийг тодорхойлох стандарт аргууд (зүтгүүрийн машины хөдөлгүүрийг оруулаагүй болно) 2. MNS IEC 60034-30-1:2019 Эргэлдэгч цахилгаан машин: Сүлжээнээс ажилладаг хувьсах гүйдлийн хөдөлгүүрийн А.Ү.К-ийн ангилал (IE код) 3. MNS IEC 60076-20: 2019 Хүчний трансформатор – Бүлэг 20: Эрчим хүчний үр ашиг 4. MNS IEC 60076-8:2019 Хүчний трансформаторын гарын авлага
	Цахилгаан тоног төхөөрөмжтэй холбоотой стандарт /Шошгожуулалтын журам /	<ol style="list-style-type: none"> 1. IEC 62552-3:2020 Ахуйн хэрэглээний зориулалттай хөргөгч хөлдөөгч, тэдгээрийн үр ашгийн үзүүлэлт, туршилт хийх аргууд; 2. IEC 60456:2020 Ахуйн хэрэглээний зориулалттай угаалгын машин, тэдгээрийн үр ашгийн үзүүлэлт, туршилт хийх аргууд; 3. IEC 60350-1: 2020 Цахилгаан зүүх буюу плитк тэдгээрийн үр ашгийн үзүүлэлт, туршилт хийх аргууд;
3 <i>Европын холбоо /EN/</i>	Эрчим хүчний аудит	<p>MNS EN 16247 Эрчим хүчний аудит. 4 бүлэг стандарт:</p> <ol style="list-style-type: none"> 1. <i>MNS EN16247-1:2019 Эрчим хүчний аудит. Ерөнхий шаардлага,</i> 2. <i>MNS EN16247-2:2019 Эрчим хүчний аудит Барилга,</i> 3. <i>MNS EN16247-3:2019 Эрчим хүчний аудит. Үйлдвэрлэл,</i> 4. <i>MNS EN16247-4:2019 Эрчим хүчний аудит Тээвэр</i>



ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2024 онд үндэсний болгон батлуулах стандартууд

	Байгууллага	Зориулалт	Стандартууд
1	Олон улсын стандартын байгууллага	Эрчим хүчний менежментийн тогтолцооны бүлэг стандарт	1. ISO 50046:2019, Эрчим хүчний хэмнэлтийг урьдчилан таамаглах ерөнхий аргууд 2. ISO 50047:2016, Эрчим хүчний хэмнэлт — Байгууллагын түвшинд эрчим хүчний хэмнэлтийг тодорхойлох 3. ISO 50049:2020, Улс орон, бүс нутаг, хотын түвшинд эрчим хүчний үр ашиг, эрчим хүчний хэрэглээний өөрчлөлтийг тооцоолох арга
2	Европын холбоо	Хэмжилт баталгаажуулалттай холбоотой стандарт	1. EN 1434-1:2016, Дулааны эрчим хүчний тоолуур, Хэсэг 1: Ерөнхий шаардлага 2. EN 1434-2:2016, Дулааны тоолуур эрчим хүчний тоолуур, Хэсэг 2: Сүүрилуулахад тавигдах шаардлага 3. EN 1434-3:2016, Дулааны тоолуур эрчим хүчний тоолуур, Хэсэг 3: Өгөгдөл, мэдээллийн солилцоо ба интерфейс 4. EN 1434-4:2016, Дулааны тоолуур эрчим хүчний тоолуур, Хэсэг 4: Түршилт, тохируулга хийх

Тайлбар: Төрийн өмчийн байгууллагуудыг тоолууржуулах тухай 144-р тогтоолын хэрэгжилтийг хангахад дулааны тоолуурыг стандартыг шинэчлэн сайжруулах хүрээнд Европын холбооноос 2016 онд шинэчлэн баталсан дулааны тоолуурын EN 1434 багц стандартыг үндэсний стандарт болгон батлуулах ажлыг зохион байгуулсан. ЭХЭЗХ -ийн эрдмийн зөвлөлөөр орохоор бэлтгэгдэж байна. - Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн. Стандарт хэмжилзүйн газрын дэргэдэх Эрчим хүчний техникийн хорооны хурлаар оруулахаар хүргүүлсэн





ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, НИЙТЭД СУРТАЛЧЛАХ, ТАНИН МЭДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Сурталчилгаа

- Сурталчилгааны материал бэлтгэх, түгээх- **100** гаруй материал
- Өдөрлөг, уралдаан зохион байгуулах – **16** төрөл

Сургалт

- Сургалт **4109** багш **140000** хүүхэд 25 удаа-**3787** багш, ажилтан 15 аанб - **500** хүн
- Аялал-сургалт 8 удаа-**306** хүн

Цахим систем

<http://ecc.erc.gov.mn>
Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийн цахим мэдээллийн систем бий болгож хөгжүүлэн зөвлөмж, мэдээлэл түгээж байна.

Хамтын ажиллагаа

- Нийслэлийн болон орон нутгийн боловсролын газар
- Нийслэлийн болон орон нутгийн сургуулийн өмнөх боловсролын байгууллага
- Ерөнхий боловсролын сургууль
- Аж ахуйн нэгж, байгууллага
- Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд
- Төрийн болон төрийн бус байгууллагууд
- Орон нутгийн Засаг даргын тамгын газар
- Олон улсын байгууллагууд

Хяналт

- Санал асуулга авах
- Тайлан авах



ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, НИЙТЭД СУРТАЛЧЛАХ, ТАНИН МЭДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

График видео сурталчилгаа

15 төрөл

1. Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулиас
2. Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө
3. Эрчим хүч түүний үнэ цэнэ
4. Эрчим хүчийг хэрхэн хэмнэх вэ?
5. Барилгын дулааны хэмнэлт г.м

Хүүхдүүд, багш нарт зориулсан

1. Цахим **контент** 3 төрөл
2. Зурагт хуудас /А3/ 5 төрөл
2. Хичээлд ашиглах **брошур** 30 төрөл
3. Номын **хавчуурга**ны загвар 12 төрөл
4. “Би эрчим хүчээ хэмнэх аргаас мэдэж чадлаа” асуулт хариултын **тоглоом** /1-5 анги тус бүрээр/
5. Туршлагатай багш нарын заасан **видео хичээл** - 10 төрөл /1-5-р анги/
6. Туршлагатай багш нарын заасан **видео хичээл** - 6 төрөл /өсвөр үе/
7. Өсвөр насныханд зориулсан “Эрчим хүч-үйлдвэрлэл, хэрэглээ, хэмнэлт” **гарын авлага-ном**

Бодит видео сурталчилгаа

8 төрөл

Олны танил урлаг соёлын хүмүүсийг оролцуулсан “Яг энэ мөчөөс эхлэн эрчим хүчээ хэмнэцгээе” уриалга бүхий бодит сурталчилгаа

ФМ сурталчилгаа

5 төрөл

Олны танил урлаг соёлын хүмүүсийг оролцуулсан “Яг энэ мөчөөс эхлэн эрчим хүчээ хэмнэцгээе” уриалга бүхий радиогоор дамжуулах сурталчилгаа

Гарын авлага

10 төрөл

1. Эрчим хүч хэмнэх нь ямар ач холбогдолтой вэ?
2. Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль бидэнд хэрэгтэй юу?
3. Эрчим хүч хэмнэх энгийн аргад суралцаарай.
4. Та хэдэн төгрөгний эрчим хүч хэрэглэдэг вэ? г.м

Зөвлөмж /А4/

4 төрөл

1. ААНБ-ын оргил ачааллын хэрэглээг бууруулах, эрчим хүч хэмнэх, үр ашигтай хэрэглэх арга замууд
2. Айл өрхөд оргил ачааллын хэрэглээг бууруулах, эрчим хүч хэмнэх, үр ашигтай хэрэглэх арга замууд
3. ААНБ-д эрчим хүч хэмнэх зөвлөмж
4. Айл өрхөд эрчим хүч хэмнэх зөвлөмж



ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, НИЙТЭД СУРТАЛЧЛАХ, ТАНИН МЭДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР



FACEBOOK

ЭХЗХ-ны албан ёсны Facebook хуудсаар эрчим хүчний системийн оргил ачааллын мэдээ, хэмнэлт, үр ашгийн зөвлөмж, мэдээ, мэдээллийг олон нийтэд тогтмол хүргэн ажиллаж байна. Пэйж хуудас **12000** гаруй like-тай, **14000** гаруй дагагчтай болсон.

ТВ

МҮОНТ-ээр хэмнэлтийн контентыг өдөр бүр тогтмол цагуудад давталттайгаар цацуулж байна. NTV, UBS, DBS зэрэг 11 телевизээр эрчим хүчний хэмнэлтийн видео шторкуудыг оргил ачааллын саруудад өдөр бүр тогтмол цагуудад давталттайгаар цацуулсан.

ЦАХИМ

Сурталчилгааны материалуудыг эрчим хүчний хэмнэлт, үр ашгийн ecc.erc.gov.mn цахим хуудас, [youtube](https://www.youtube.com/), зарим facebook хуудсанд байршуулан түгээж байна.

ӨДӨРЛӨГ

Олон нийтэд зориулсан **16** гаруй төрлийн **өдөрлөг, аян, уралдаан** зэрэг арга хэмжээг зохион байгуулахад оролцож хэмнэлт, үр ашгийн гарын авлага, зөвлөмж мэдээллүүдийг олон нийтэд түгээсэн.

Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийн видео шторкууд, брошур, зурагт хуудсыг:

- ✓ Үүрэг хүлээсэн хэрэглэгчид
- ✓ 21 аймгийн зохицуулах зөвлөлийн гишүүд
- ✓ Ерөнхий боловсролын сургуулиуд
- ✓ Түгээх, хангах ТЗЭ байгууллагууд
- ✓ Сургалт, зөвлөгөөнд оролцогчид болон хэрэглэгчдэд түгээсэн.



ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, НИЙТЭД СУРТАЛЧЛАХ, ТАНИН МЭДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР



ЭРЧИМ ХҮЧНИЙ
ХЭМНЭЛТ, ҮР АШИГ

Хайх утгаа оруулна уу



ЭХЛЭЛ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ҮЙЛЧИЛГЭЭ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН ХЭРЭГЛЭГЧ ОРОН НУТАГ СУРГАЛТ ЗӨВЛӨМЖ ХҮҮХЭД МЭДЭЭ



<http://ecc.erc.gov.mn>

хэмнэлт, үр ашгийн цахим мэдээллийн системийг 2018 онд шинээр бий болгон хөгжүүлэн ажиллаж байна.

- Цахим системээр дамжуулан хэрэглэгч олон нийтэд эрчим хүч хэмнэх, үр ашигтай хэрэглээний талаарх мэдээллийг тасралтгүй түгээх нөхцөл бүрдсэн.
- Цахим мэдээллийн системээр үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн мэдээллийн хуудас, төлөвлөгөө, тайлан, төрийн захиргааны болон орон нутгийн байгууллагын эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээллийг хүлээн авч, тайлан, төлөвлөгөөнүүдийг нэгтгэн ашиглаж байна.



ЭРЧИМ ХҮЧНИЙ
АУДИТОРУУДЫГ
ОЛОН УЛСЫН
СУРГАЛТЫН СОН...



ХУВИЙН ХЭВШЛИЙН
ЕБС-ИУД ЭРЧИМ
ХҮЧНИЙ ХЭМНЭЛТЭД
НЭГ...



Эрчим хүчний
аудитор, эрчим
хүчний аудитын
байгуул...



ЭХ ДЭЛХИЙН ЦАГТ
ЭРЧИМ ХҮЧНИЙ
ЗОХИЦУУЛАХ ХОРОО
НЭГД...



ХҮҮХЭД БҮР
ИРЭЭДҮЙН УХААЛАГ
ХЭРЭГЛЭГЧИД
БОЛНО



БАРИЛГЫН ЭРЧИМ
ХҮЧНИЙ ГЭРЧИЛГЭЭ
ОЛГОЛОО



ОЛОН УЛСЫН ЭРЧИМ ХЭМНЭЛТИЙН БОДЛОГО, ХЭРЭГЖИЛТ

01

Дэлхийд

Эрчим хүчний хэрэглээ өндөр Улс орнууд Бразил, Хятад, Энэтхэг, Индонез, Мексик, Өмнөд Африк зэрэг улсууд дэлхийн эрчим хүчний гуравны нэгийг хэрэглэдэг бөгөөд энэ цаашид 40% хүртэл өсөх төлөвтэй байна.

Улс орнуудтай хамтран ажиллах гурван үндсэн зорилго:

- Эрчим хүчний хэмнэлтээр Аюулгүй, Тогтвортой эрчим хүчний системийг бий болгох.
- Эрчим хүчний хэмнэлт, үр ашигтай бодлого стратегийн загварыг боловсруулах.
- Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийн үзүүлэлтүүдийг тасралтгүй сайжруулах бодлогоор дамжуулан зорилт тодорхойлж, ахиц дэвшлийг хянах.



02

ЯПОН

Эрчим хүчний нийлүүлэлтийн таамаглал болон бодит эрэлт нийлүүлэлтийн тэнцвэртэй холбогдох мэдээллийг олон нийтэд түгээх аргуудыг Японд сайн зохион байгуулсан.

Хэрэглэгчдэд цахилгаан эрчим хүч хэмнэлтийн урамшуулал нь зөвхөн "богино хугацаанд авах урамшуулал" бус урт хугацаандаа зөв амьдралын хэвшил, хэв маягаа өөрчлөхөд чухал ач холбогдолтой гэсэн ойлголтыг өгсөн.

Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн, технологи, үйлчилгээ, инновацийг нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг дэмжих бодлого баригсан.



03

Өмнөд африк

Эрчим хүчний **НӨӨЦИЙН БОЛОН БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ** **НАЙДВАРТАЙ НЭГДСЭН** боловсруулж хэрэгжүүлсэн.

- Урт 5-10 жил,
- Дунд 1-5 жил,
- Богино Сар,
- Шууд хэрэгжүүлэх 24 цаг

INTEGRATED RESOURCE AND RESILIENCE PLANNING (IRRP)



04

Хятад улс

Хятад улс 2021, 2022 онуудад Эрчим хүчний хэмнэлт үр ашгийг эрчимжүүлэх томоохон бодлогуудаа шинэчлэн баталсан. Үүнд:

- Хотжилт, хөдөө аж ахуйн хөгжилд нүүрсхүчлийн хийг бууруулах, тэг болгох үндэсний хөтөлбөр
- Аж үйлдвэрийн салбарын эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

Эдгээр бодлогын баримт бичгүүд нь:

2030 он гэхэд барилга байгууламжийн цахилгаан хангамж, үр ашгийг сайжруулах, хуучин цахилгаан хөдөлгүүрүүдийг шинэчлэх зорилтууд багтсан.

2022 оны 2-р сард тогтоосон эрчим хүчний гүйцэтгэлийн хамгийн бага стандарт /MEPS/ нь эрчим хүч их хэрэглэдэг 17 үйлдвэрт нэвтрүүлэх зорилготой юм





03 ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ӨӨРЧЛӨХ
ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА





ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ӨӨРЧЛӨХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Эрчим хүч хэмнэлтийг дэмжихэд сошиал, эдийн засгийн хүчин зүйлсийг анхаарах шаардлагатай.





ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ӨӨРЧЛӨХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Хууль эрх зүйн үндэслэл

- Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж заасан.
- ЗГ-ын 2017 оны 274 дүгээр тогтоолоор батлагдсан Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр (2018-2022 он)-ийн 3.1.1-т “Эрчим хүч хэмнэх үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох” зорилтыг дэвшүүлсэн байсан.
- ЭХЯ-аас хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний 2019, 2020 оны тайлангийн дүгнэлтэд “Эрчим хүч хэмнэх үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байна.” гэж зөвлөмж өгсөн.
- Эрчим хүчний сайдын 2023 оны А/51 дүгээр тушаалаар байгуулагдсан нэгдүгээр ажлын хэсгийн төлөвлөгөөнд “Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль болон бусад хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулах” гэж тусгагдсан.

Практик хэрэгцээ, шаардлага

- Эрчим хүч хэмнэлтийн бодлогыг орчин олон улсын сайн туршлагыг судалж өөрчлөлт оруулах.
- Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн эрчим хүчний аудитын үйл ажиллагаа, эрчим хүч хэмнэлтийн үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага, үүрэг хүлээсэн хэрэглэгч, эрчим хүч хэмнэлтийн менежерийн эрх үүрэг тэдгээртэй холбоотой харилцаа
- Дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгохтой холбоотой харилцаа
- Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлийн болон Эрчим хүч хэмнэлтийн талаар төрийн захиргааны төв байгууллага, АНЗД-ын бүрэн эрх, тэдгээртэй холбоотой харилцааг тодорхой, зохицуулалтыг боловсронгуй болгох
- Эрчим хүчний хэрэглээний стандарт, босго хэмээг нарийвчлан тогтоох, барилгын эрчим хүчний хэрэглээ, гэрчилгээний эрх зүйн зохицуулалт
- Эрчим хүчний хэмнэлтийг хэмжих тооцох, баталгаажуулах аргачлал, хууль эрх зүйн зохицуулалт
- Бусад хууль тогтоомж, хөгжлийн бодлоготой нийцүүлэх



04 ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН
ТАЛААР





Хууль эрх зүйн шинэчлэл

Demand Side Management

Demand Response

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийг шинэчлэх, дагалдах журам, зохицуулалтын баримт бичгийг боловсруулах

Хэрэглээ талын удирдлага

Хэрэгцээг удирдах
ЧАДЛЫН
ДУТАГДАЛ=ХЭМНЭЛТ

- Урамшуулал, шошго, хамгийн бага гүйцэтгэлийн стандартыг нэвтрүүлэх;
- Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийн зорилт тогтоох;
- Салбар хоорондын болон оролцогч талуудын үүрэг оролцоо, уялдаа холбоог сайжруулах;
- Хэрэглэгчийг эдийн засгийн үйл ажиллагааны салбар, дэд ангиллаар ангилах, хэрэглээний менежементийг сайжруулах;
- Эрчим хүчний хэмнэлтийг хэмжих, тооцох, баталгаажуулах тогтолцоог бий болгох;
- Хэмнэлтийг дэмжсэн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн механизмыг бүрдүүлэх;

Нөөцийг хэмнэхийн тулд эцсийн хэрэглэгч дээрх эрчим хүчний үр ашигтай хэрэглээг дэмжих арга хэрэгсэл.

Нөөцийн хомсдолыг давах, системийн найдвартай байдал, үр ашгийг сайжруулахын тулд системийн оргил ачааллын үед эцсийн хэрэглэгчийн хэрэглээг бууруулахад чиглэсэн салбарын байгууллагуудын хамтран хэрэгжүүлдэг арга хэрэгсэл.




ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТАЛААР

Хэрэглэгчдийн хэрэглээг хэмжих, хэрэглээгээрээ төлбөрөө төлдөг болгох



Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ, өнөөгийн үнэ цэнийн талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх

Хэрэглэгчдийн хэрэглээний бүтцийг нарийвчлан тодорхойлох



Олон нийтэд чиглэсэн арга хэмжээний үр дүнг тооцож үнэлэх

Хэрэглээний ангилал, босго хэмжээг стандартаар тогтоох, хэмнэлтийн механизмыг урамшуулалд суурилсан тогтолцоонд үе шаттай шилжүүлэх



Сургуулийн өмнөх, бага, дунд, ахлах ангийн сурах бичиг, хичээлийн агуулгад эрчим хүч хэмнэлтийн зохистой хэрэглээний талаар тусгуулах



ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТАЛААР

2

б) Эрчим хүчний хэмнэлт, хууль тогтоомжийн хэрэгжилт, үр нөлөөг үнэлэх, хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг тодорхойлох болон Төслийн үйл ажиллагааны үр нөлөөг тогтоох зорилгоор эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчдээс авах судалгааны ажлыг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлнэ.

в) Ажлын хэсгийг шаардлагатай мэдээлэл, зөвлөмжөөр хангана.

г) Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрээнд оролцогч талуудын уулзалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

ГУРАВ. БУСАД

3.1.Талууд энэхүү хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтран батлах бөгөөд, хавсралт нь санамж бичгийн нэгэн адил хүчин төгөлдөр байна.

3.2.Санамж бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналыг талууд бичгээр тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр тодотгож баталж болно.

3.3.Талууд үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд эрхлэн хариуцах эрх бүхий тус бүр нэг нэг ажилтныг томилон ажиллуулж санамж бичгийн биелэлт, төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг улирал, хагас бүтэн жилээр дүгнэнэ.

3.4.Санамж бичгээр зохицуулагдаагүй аливаа бусад асуудлыг зөвшилцлийн үндсэн дээр хойшдын яриа, хэлэлцээрт тусган шийдвэрлэнэ.

3.5.Санамж бичгийг талууд гурван жилийн хугацаатай байгуулж байгаа бөгөөд хугацаа дуусахаас өмнө аль нэг талын санаачилгаар цуцалж болно. Энэ тохиолдолд санамж бичгийг цуцлах хүсэлтээ ажлын 5 хоногийн дотор нөгөө талдаа урьдчилан мэдэгдэнэ.

3.6.Энэхүү санамж бичгийг 2 хувь үйлдэх бөгөөд талууд нэг нэг хувийг өөрт хадгална.

3.7.Санамж бичигт талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН:

ГОУХАН-ИЙН "JUST TRANSITION-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЭРХ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ БА ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЧАДАВХЫГ САЙЖРУУЛАХ" ТӨСЛИЙН УДИРДАГЧ



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРСОНЫ ДАРГА



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРСОНЫ ДАРГА

Э.ТҮВШИНЧУЛУУН



ГОУХАН-ИЙН "JUST TRANSITION-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЭРХ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ БА ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЧАДАВХЫГ САЙЖРУУЛАХ" ТӨСЛИЙН УДИРДАГЧ

Л.ЗАЯА

2024 оны 05 дугаар сарын 25

ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Улаанбаатар хот

Д/д	Арга хэмжээ	Хурал үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хариуцагч	Хамтран хэрэгжүүлэгч	Гүйцэтгэх хугацаа				Хэрэгжүүлэх арга хэмжээ
						2024 он		2025 он	2026 он	
						1-р хагас	2-р хагас			
Зорилт 1. Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, батлуулах;										
1.1	Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийг шинэчлэн боловсруулах практик хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох	Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийг шинэчлэн боловсруулах практик хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох судалгааны ажлын даалгаврыг боловсруулах	Эрчим хүчний салбарын холбогдох байгууллагын төлөөлөл, мэргэжилтэн, аудитор, хэмнэлтийн менежерүүдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, судалгааны аргачлал, асуумж зэрэг бэлэн болсон байна	ГОУХАН	ЭХЗХ					ЭХЗХ: Судалгааны ажлын даалгаврыг боловсруулах.
1.2	Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийг шинэчлэн боловсруулах практик хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох	Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийг шинэчлэн боловсруулах практик хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох зөвлөх багийн оонгох, гэрээ байгуулах.	Судалгааны ажлын гүйцэтгэх зөвлөх багийн байгууллагатай гэрээ байгуулсан байна.	ГОУХАН	ЭХЗХ					GIZ: Судалгааны байгууллагатай гэрээлэх, санхүүжүүлэх.
1.3		Судалгааны ажлын тайланг хэлэлцүүлж хүлээн авсан байна.	Судалгааны ажлын тайлан.	ГОУХАН	ЭХЗХ					
1.4	Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг дахин хийж;	Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлсэн байна.	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан.	ЭХЗХ	ГОУХАН					GIZ: Үнэлгээ хийж гүйцэтгэх компани, мэргэжилтэнтэй гэрээлнэ.



ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТАЛААР

Санамж бичгийн хавсралтаар баталсан үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлэхэд бүх талаар дэмжлэг үзүүлнэ.

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийг шинэчлэн боловсруулах.


Хууль тогтоомжийн хэрэгжилт, үр нөлөөг үнэлэх, хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг тодорхойлох болон Төслийн үйл ажиллагааны үр нөлөөг тогтоох зорилгоор авах судалгааны ажлыг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлнэ.

Ажлын хэсгийг шаардлагатай мэдээлэл, зөвлөмжөөр хангана

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрээнд оролцогч талуудын уулзалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.



Санамж бичигт



Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй уялдуулан дагалдан батлагдах журам, зохицуулалтын баримт бичгүүдийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх.

Санал, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг санамж бичигт заасны дагуу дэмжиж, хамтран ажиллах.

Санамж бичгийн хавсралтаар баталсан үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.



ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТАЛААР

ЭХЗХ болон ГОУХАН хамтран хэрэгжүүлэх Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийг шинэчлэн боловсруулах ажлын төлөвлөгөө

Тус зорилтын хүрээнд 9 арга
хэмжээг хэрэгжүүлэхээр
төлөвлөсөн

Тус зорилтын хүрээнд 7 арга
хэмжээг хэрэгжүүлэхээр
төлөвлөсөн

Зорилт 1

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд **нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, батлуулах;**

Зорилт 2

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах;

Зорилт 3

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн **шинэчилсэн найруулгын хүрээнд холбогдох дүрэм, журмуудыг шинээр боловсруулах;**


Зорилт 4

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн **шинэчилсэн найруулгын хүрээнд зохицуулалтын баримт бичгүүдэд нэмэлт өөрчлөлт оруулах;**

Тус зорилтын хүрээнд 7 арга
хэмжээг хэрэгжүүлэхээр
төлөвлөсөн

Тус зорилтын хүрээнд 2 арга
хэмжээг хэрэгжүүлэхээр
төлөвлөсөн

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА.



<http://erc.gov.mn>

<http://ecc.erc.gov.mn>